

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/4/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага.....	16
5.2 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МХС	Мэдээлэл Холбооны Сүлжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
НҮТББ	Нийтийн үйлчилгээний төрийн бус байгууллага
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МЯГМАРНАРАН
ТАНАА

2026.03.25 № 790
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 555,150.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5-д заасан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” судалгааны ажлын 19,500.0 мянган төгрөгийн гэрээг Хууль дээдлэх ёс НҮТББ-тай байгуулж, гүйцэтгэлээр алданги тооцож 18,564.0 мянган төгрөг олгосон байна. Тус судалгааны ажлын даалгаврыг зөв боловсруулаагүйгээс судалгааны тайлан нь хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал зөвлөмж дутмаг, нөхцөл байдал тайлбарласан байгаа нь хангалттай үр дүнгүй байна;
- Тус сан нь “Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх /182 сум/” арга хэмжээг нээлттэй тендер зарлаж 166,526.4 мянган төгрөгийн 182 ширхэг ПОС машин

худалдан авч бараа материалд бүртгэн, Монгол шуудан ХК-ийн ашигт ажиллагааг сайжруулахаар тус ПОС машинуудыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын А/121 тоот дугаар тушаалаар балансаас балансад шилжүүлэн мөнгөн бус татаас олгосон байна;

- Тайлант оны эцэст 2-5 жилийн насжилттай 183,388.9 мянган төгрөг, 5-с дээш жилийн насжилттай 120,753.3 мянган төгрөг, нийт 304,142.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах боломжгүй, найдваргүй авлага болох эрсдэлтэй байна.

Дээр дурдсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 40 дүгээр зүйлийн 40.2.2 тус тус нийцэхгүй бөгөөд толилуулга, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй орон нутгийн алслагдсан сумын багт хөдөлгөөнт холбооны үйлчилгээний 6 төслийн нийт 4,753,294.8 мянган төгрөгийн зардлыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын А/131 дугаар тоот тушаалаар зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсөвт цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 148,038.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардалд 23,303.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 29,456.6 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 21,519.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардалд 6,500.0 мянган төгрөгийг тайлант оны төсөвт төлөвлөж байгаа нь цаашид сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах эрсдэл үүссэн байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б. Р. Ц. НАРАНЧИМЭГ*



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,855,012,829.59	27,348,332,196.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,608,731,487.74	20,375,645,751.18
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,608,731,487.74	20,375,645,751.18
31210	Төгрөг	18,608,731,487.74	20,375,645,751.18
31211	Төрийн сангийн харилцах	18,608,731,487.74	20,375,645,751.18
33	АВЛАГА	579,338,975.10	328,630,021.15
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	579,338,975.10	328,630,021.15
35	БАРАА МАТЕРИАЛ	-	197,608,900.00
35400	Хангамжийн материал	-	197,608,900.00
35410	Бичиг хэргийн материал	-	909,900.00
35420	Аж ахуйн материал	-	1,035,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	195,664,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,666,942,366.75	6,446,447,524.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	10,666,942,366.75	6,446,447,524.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,070,783.28	2,850,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,070,783.28	2,850,000.00
39200	Биет хөрөнгө	4,070,783.28	2,850,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,500,000.00	2,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,333,333.36)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,175,200.00	7,175,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,271,083.36)	(7,175,200.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	29,859,083,612.87	27,351,182,196.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,085,788,529.10	1,026,654,593.07
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,085,788,529.10	1,026,654,593.07
41300	Өглөг	747,644,734.44	1,000,113,308.99
41360	Бусад өглөг	747,644,734.44	1,000,113,308.99
41361	Байгууллагад төлөх өглөг	747,644,734.44	1,000,113,308.99
41400	Урьдчилж орсон орлого	2,338,143,794.66	26,541,284.08
41440	Бусад урьдчилж орсон орлого	2,338,143,794.66	26,541,284.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,773,295,083.77	26,324,527,603.26
51	Засгийн газрын хувь оролцоо	26,773,295,083.77	26,324,527,603.26
51100	Засгийн газрын оруулсан капитал	23,293,144.00	23,293,144.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	23,293,144.00	23,293,144.00
51200	Хуримтлагдсан үр дүн	26,750,001,939.77	26,301,234,459.26
51210	Өмнөх үеийн үр дүн	21,781,242,183.50	26,675,882,181.56
51220	Тайлант үеийн үр дүн	4,968,759,756.27	(374,647,722.30)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	29,859,083,612.87	27,351,182,196.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	9,803,511,091.03	9,769,881,307.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,803,511,091.03	9,769,881,307.73
120	Нийтлэг татварын бус орлого	9,803,511,091.03	9,769,881,307.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,803,511,091.03	9,767,031,307.73
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,803,511,091.03	9,767,031,307.73
120009	Бусад орлого	-	2,850,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,621,411,375.76	9,859,464,030.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,621,411,375.76	9,859,464,030.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,621,411,375.76	9,859,464,030.03
2104	Хангамж, бараа материалын зардал	1,312,300.00	3,247,350.00

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	-	2,026,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,312,300.00	756,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	465,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,616,057,892.00	9,852,145,896.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,615,397,892.00	9,852,145,896.75
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	660,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,041,183.76	4,070,783.28
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,041,183.76	4,070,783.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,182,099,715.27	(89,582,722.30)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,213,339,959.00	285,065,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,213,339,959.00	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	285,065,000.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(1,213,339,959.00)	(285,065,000.00)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	4,968,759,756.27	374,647,722.30)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,297,608,518.87	7,974,186,295.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,297,608,518.87	7,974,186,295.89
120	Нийтлэг татварын бус орлого	8,297,608,518.87	7,974,186,295.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,009,136,304.27	7,632,017,992.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,009,136,304.27	7,632,017,992.89
120009	Бусад орлого	288,472,214.60	342,168,303.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,842,546,192.00	6,207,272,032.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,842,546,192.00	6,207,272,032.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,842,546,192.00	6,207,272,032.45
2104	Хангамж, бараа материалын зардал	1,312,300.00	5,192,250.00
210401	Бичиг хэрэг	-	2,936,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,312,300.00	756,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,841,233,892.00	6,202,079,782.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,840,573,892.00	6,202,079,782.45
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	660,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,455,062,326.87	1,766,914,263.44
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,455,062,326.87	1,766,914,263.44
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,153,669,160.87	18,608,731,487.74
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,608,731,487.74	20,375,645,751.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	-	21,781,242,183.50	21,804,535,327.50
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	-	21,781,242,183.50	21,804,535,327.50
Тайлант үеийн үр дүн	-	-	4,968,759,756.27	4,968,759,756.27
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	-	26,750,001,939.77	26,773,295,083.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(74,119,758.21)	(74,119,758.21)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00	-	26,675,882,181.56	26,699,175,325.56
Тайлант үеийн үр дүн	-	-	(374,647,722.30)	(374,647,722.30)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	-	26,301,234,459.26	26,324,527,603.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,163,273,900.00	7,632,017,992.89	(2,468,744,092.89)	147.8
Татварын бус орлого	5,163,273,900.00	7,632,017,992.89	(2,468,744,092.89)	147.8
Нийтлэг татварын бус орлого	5,163,273,900.00	7,632,017,992.89	(2,468,744,092.89)	147.8
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	5,163,273,900.00	7,632,017,992.89	(2,468,744,092.89)	147.8
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,308,973,900.00	6,117,572,304.00	2,191,401,596.00	73.6
УРСГАЛ ЗАРДАЛ	8,308,973,900.00	6,117,572,304.00	2,191,401,596.00	73.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,302,473,900.00	6,117,572,304.00	2,184,901,596.00	73.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,038,100.00	-	148,038,100.00	0.0
Нэмэгдэл	125,038,400.00	-	125,038,400.00	0.0
Унаа хоолны хөнгөлөлт	22,999,700.00	-	22,999,700.00	0.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,303,800.00	-	23,303,800.00	0.0
Тэтгэврийн даатгал	15,846,500.00	-	15,846,500.00	0.0
Тэтгэмжийн даатгал	1,864,300.00	-	1,864,300.00	0.0
ҮОМШӨ-ний даатгал	932,200.00	-	932,200.00	0.0
Ажилгүйдлийн даатгал	932,200.00	-	932,200.00	0.0
Эрүүл мэндийн даатгал	3,728,600.00	-	3,728,600.00	0.0
Хангамж, бараа материалын зардал	25,891,000.00	5,192,250.00	20,698,750.00	20.1
Бичиг хэрэг	10,057,000.00	2,936,000.00	7,121,000.00	29.2
Тээвэр, шатахуун	9,456,600.00	-	9,456,600.00	0.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,589,100.00	756,250.00	1,832,850.00	29.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,788,300.00	1,500,000.00	2,288,300.00	39.6

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эд хогшил, урсгал засварын зардал	29,456,600.00	-	29,456,600.00	0.0
Багаж, техник, хэрэгсэл	29,456,600.00	-	29,456,600.00	0.0
Томилолт, зочны зардал	21,519,300.00	-	21,519,300.00	0.0
Дотоод албан томилолт	20,267,700.00	-	20,267,700.00	0.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,251,600.00	-	1,251,600.00	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,052,772,000.00	6,112,380,054.00	1,940,391,946.00	75.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,049,800,000.00	6,112,380,054.00	1,937,419,946.00	75.9
Даатгалын үйлчилгээ	230,000.00	-	230,000.00	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	210,000.00	-	210,000.00	0.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,000.00	-	32,000.00	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,500,000.00	-	2,500,000.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,493,100.00	-	1,493,100.00	0.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,493,100.00	-	1,493,100.00	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	-	6,500,000.00	0.0
Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	-	6,500,000.00	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	-	6,500,000.00	0.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(3,145,700,000.00)	1,514,445,688.89	(4,660,145,688.89)	(48.1)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,145,700,000.00	(1,514,445,688.89)	4,660,145,688.89	(48.1)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	3,145,700,000.00	(1,514,445,688.89)	4,660,145,688.89	(48.1)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	17,956,709,707.84	(17,956,709,707.84)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,471,155,396.73	(19,471,155,396.73)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь эрхэм зорилгоо “Төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх шинэчлэх зориулалтаар, үйлчилгээ явуулах” гэж тодорхойлсон байна.

Тус сан нь харилцаа холбооны чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгжээс татварын дараах цэвэр ашгийн 3.0 хувийг мөнгөн хөрөнгийг санд төвлөрүүлэх, түүнийг зарцуулах ажлыг зохион байгуулж, шударга нээлттэй өрсөлдөх, эрх тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэгтэй ЦХИХХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.17-д “Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн” гэж заасны дагуу ЦХИХХС-ын 2026 оны 01 дүгээр сарын 8-ны өдрийн Б/26 тушаалаар томилогдсон Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 354 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан хавсралт “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сан нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/54 дүгээр тушаалаар баталсан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын харьяа төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,507,901.4 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,608,731.5	20,375,645.8	1,766,914.3
Авлага	579,339.0	328,630.0	(250,709.0)
Бараа материал	-	197,608.9	197,608.9
Бусад эргэлтийн хөрөнгө	10,666,942.3	6,446,447.5	(4,220,494.8)
Үндсэн хөрөнгө	4,070.8	2,850.0	(1,220.8)
Нийт хөрөнгө	29,859,083.6	27,351,182.2	(2,507,901.4)
Өр төлбөр	3,085,788.5	1,026,654.6	(2,059,133.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	26,773,295.1	26,324,527.6	(448,767.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	29,859,083.6	27,351,182.2	(2,507,901.4)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данстууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 20,375,645.8 мянган төгрөг болж өмнөх оноос 1,766,914.30 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 7,974,186.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, 6,207,272.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд төрийн сангийн харилцах дансанд 19,471,155.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн /барьцаа, захиалагч хяналтын/ дансанд 904,490.4 мянган төгрөг тус тус бүртгэлтэй;
- Авлагын эцсийн үлдэгдэл 328,630.0 мянган төгрөг болж өмнөх оноос 250,709.0 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас тайлант онд 7,553,118.5 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагын тооцоо үүсч, 7,803,827.4 мянган төгрөгийн авлагын тооцоо төлөгдсөнөөс шалтгаалсан;
- Бараа материалын эцсийн үлдэгдэл 197,608.9 мянган төгрөг болж өмнөх оноос 197,608.9 мянган төгрөгөөр өссөн нь 201,319.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 3,711.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой;
- Бусад эргэлтийн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 6,446,447.5 мянган төгрөг болж өмнөх оноос 4,220,494.8 мянган төгрөгөөр буурсан нь сангийн хөрөнгөөр 817,865.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авч, 4,753,294.84 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээний үйлчилгээг үзүүлж дууссан үйлчилгээний зардлыг ЦХИХХС-ын 2025 оны А/131 тоот тушаалаар тайлант оны зардалд хүлээн зөвшөөрч, 40,988.64 мянган төгрөгийн хөрөнгийг “Радио телевизийн үндэсний сүлжээ”, 77,550.0 мянган төгрөгийн хөрөнгийг ЦХИХХС-ын 2025 оны А/97 дугаар тушаалаар Төв аймгийн Засаг даргын тамгын газар, Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар, Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар, 166,526.4 мянган төгрөгийн хөрөнгийг ЦХИХХС-ын 2025 оны А/121 тоот тушаалаар “Монгол шуудан” ХК-д тус тус шилжүүлсэнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгийн цэвэр дүнгээр эцсийн үлдэгдэл 2,850.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,220.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдэл болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 512 дугаар тогтоолоор ашиглалтын

хугацаа дууссан 1 тээврийн хэрэгслийн үнийг 2,850.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, бүртгэснээс шалтгаалсан;

- Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 1,026,654.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,059,133.9 мянган төгрөгөөр буурсан нь 2,312,276.1 мянган төгрөгийн урьдчилж олсон орлогыг тайлант онд орлогоор хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой. Өр төлбөрийн үлдэгдлийн 1,000,113.3 мянган төгрөг буюу 97.4% нь чанарын баталгааны барьцаа, хүлээгдэж буй захиалагч хяналтын зардлын төлбөр 26,541.2 мянган төгрөг буюу 2.6 хувийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, компаниудын төвлөрүүлсэн урьдчилж орсон орлого тус тус эзэлж байна;
- Засгийн газрын хувь оролцооны эцсийн үлдэгдэл 26,324,527.6 болж өмнөх оноос 448,767.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үйл ажиллагааны орлогоос 8,310,824.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж ЦХИХХС-ын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/25 тоот албан бичгээр дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс материаллаг өөрчлөлт гарсан зардлын үзүүлэлтийг дурдвал цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 7,308.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 1,319.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 2025 оны төсвийг 8,319,451.8 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,319,451.8 мянган төгрөгөөр тооцон баталсан бөгөөд тайлант оны батлагдсан төсвийг 10,478.2 мянган төгрөгөөр бууруулж 8,308,973.9 мянган төгрөг болгон тодотгосон байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 35,147.1 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 83.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3,628.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 6.9 мянган төгрөгөөр тус тус бууруулж, хангамж, бараа материалын зардлыг 8,431.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 19,956.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн үйл ажиллагааны 7,632,018.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 6,117,572.3 мянган төгрөгийг зарцуулж, 1,514,445.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,117,572.3 мянган төгрөг буюу 73.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 148,038.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 23,303.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 20,698.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 29,456.6 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 21,519.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 1,940,391.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,493.1 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 6,500.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71302	Мэдээлэл технологийн нэгдсэн дэд бүтэц	8,308,973.9	6,117,572.2	2,191,401.7	73.6
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	252,673.9	5,192.2	247,481.7	2.1
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	-	-	-	-
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	6,500.0	-	6,500.0	-
81538	Алслагдсан орон нутагт хүрэх шуудан, харилцаа холбооны үйлчилгээ	8,049,800.0	6,112,380.0	1,937,420.0	75.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2025 онд он дамжин хэрэгжих дараах ажлуудын санхүүжилтийг урьдчилан олгосон байна. Үүнд:

- Хэт богино долгионы дахин дамжуулах станцын хамрах хүрээг нэмэгдүүлэх, өргөтгөх төслийн “Фэйд трейд” ХХК ЦХИХХЯ/2024020160 дугаартай гэрээний дагуу 40,988.6 мянган төгрөг;
- Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээ хүрээгүй алслагдсан орон нутгийн хүн амд үйлчилгээ хүргэх зорилгоор дамжуулах сүлжээний үйлчилгээ үзүүлэх /55 баг/ “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК ЦХИХХЯ/20240103158 дугаартай гэрээний дагуу 2,588,351.0 мянган төгрөгийг олгосон.

Тайлан онд шинээр хэрэгжиж, санхүүжилт олгосон дараа ажлууд байна. Үүнд:

- Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг бүс нутагт турших, нэвтрүүлэх шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж /30 цэг/ “Парламентын суваг” ЦХИХХЯ/2025020007 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэлд 77,550.0 мянган төгрөг;
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сантай холбоотой хууль, эрх зүйн өнөөгийн нөхцөл байдлыг судалгаа хийх, дүгнэлт гаргах, нэмэлт өөрчлөлт хийх эсэхэд санал, зөвлөмж боловсруулах “Хууль дээдлэх ёс” НҮТББ ЦХИХХЯ/20250603005 дугаартай гэрээний ажлын гүйцэтгэлд 19,500.0 мянган төгрөг;
- Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутгийн талаарх зах зээлийн нөхцөл байдлын судалгаа хийлгэх “Вай Инсайт” ХХК ЦХИХХЯ/20250203004 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэлд 79,300.0 мянган төгрөг;
- Сангийн хөрөнгөөр сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргах “Вай Инсайт” ХХК ЦХИХХЯ/20250203003 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэлд 97,800.0 мянган төгрөг;
- Үүрэн холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор эрчим хүчний саатал ихтэй алслагдсан багт байрших бааз станцын нөөц тэжээлийн эх үүсвэрийг шинэчлэх (10 сайт) “Ногоон-Үйлс” ХХК ЦХИХХЯ/20250102009 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэлд 532,800.0 мянган төгрөг;

- Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршил мэдээлэлд суурилсан технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх /182 сум/ “Инфосолюшн” ХХК ЦХИХХЯ/20250102010 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэлд 166,526.4 мянган төгрөг;
- Харилцаа холбооны сүлжээ хүрээгүй алслагдсан багт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх /40 хүртэлх баг/ “Мобиком корпорац” ХХК ЦХИХХЯ /20250103134 Багц 1 дугаартай гэрээний дагуу 595,000.0 мянган төгрөг, “Мобиком корпорац” ХХК Багц 2 дугаартай гэрээний дагуу 595,000.0 мянган төгрөг, “Мобиком корпорац” ХХК Багц 5 дугаартай гэрээний дагуу 695,000.0 мянган төгрөг, “Скайтел” Багц 4 дугаартай гэрээний дагуу 625,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, Г.Тэлмүүн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/114 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна..

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,621,411.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 36,214.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 9,859,464.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 272.3 хувиар өссөн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 10,144,529.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 101,445.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд нь хуульд заасан бусад хязгаарлалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7,638,245.6 мянган төгрөгийн орлогын 29 гүйлгээ, 6,184,791.6 мянган төгрөгийн зардлын 22 гүйлгээг цаг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт: "Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээ хүрээгүй алслагдсан орон нутгийн хүн амд үйлчилгээ хүргэх зорилгоор дамжуулах сүлжээний үйлчилгээ үзүүлэх /55 багт/" 2024-2025 онд хэрэгжих тендерийн техникийн тодорхойлолтыг судалгаанд үндэслэн бодитой боловсруулаагүйгээс 29 цэгийг өөрчлөн, гэрээний хугацааг 2026 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн хүртэл сунгаж захиалагчаас хамаарах шалтгаанаар "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-тай нэмэлт гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендерийн техникийн тодорхойлолтыг судалгаанд үндэслэн бодитой боловсруулж байх.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар тус санд хүргүүлсэн 59,031.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 950,454.4 мянган төгрөгийн 4 албан шаардлагын хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Биелэлт
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	59,031.5	1	59,031.5	100.0
Албан шаардлага	4	950,454.4	4	950,454.4	100.0
Нийт дүн	5	1,009,485.9	5	1,009,485.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсөвт цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, эд хогшил, урсгал засварын зардал, томиллолт, зочны зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлыг тус сангийн төсөвт төлөвлөж байгаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журамтай нийцэж байгаа эсэх;
- Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй захиалагч этгээдэд шилжүүлээгүй хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 555,150.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 251,007.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 304,142.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 555,150.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 453,704.7 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт 1: “Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж /30 цэг/-ийн 80,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж нийлүүлж байсан туршлагагүй, зар сурталчилгаа, нэвтрүүлэг хийх үйл ажиллагааны чиглэл бүхий “Парламентын суваг” ХХК-ийг шалгаруулан илт хууль бус гэрээ байгуулж, 65,917.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.”, 41 дүгээр зүйлийн 41.1.6-д “захиалагчийн энэ хуульд заасан бусад зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж, илт хууль бус тендер шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсантай холбоотой

Илрүүлэлт 2: “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5-д заасан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” судалгааны ажлын 19,500.0 мянган төгрөгийн гэрээг Хууль дээдлэх ёс НҮТББ-тай байгуулж, гүйцэтгэлээр алданги тооцож 18,564.0 мянган төгрөг олгосон байна. Тус судалгааны ажлын даалгаврыг зөв боловсруулаагүйгээс судалгааны тайлан нь хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал зөвлөмж дутмаг, нөхцөл байдал тайлбарласан байгаа нь хангалттай үр дүнгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт 3: Тус сан нь “Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх /182 сум/” арга хэмжээг нээлттэй тендер зарлаж 166,526.4 мянган төгрөгийн 182 ширхэг ПОС машин худалдан авч бараа материалд бүртгэн, Монгол шуудан ХК-ийн ашигт ажиллагааг сайжруулахаар тус ПОС машинуудыг ЦХИХХС-ын А/121 тоот дугаар тушаалаар балансаас балансад шилжүүлэн мөнгөн бус татаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төлөвлөөгүй, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар хориглосон мөнгөн бус татаас олгосон зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

1. Авлагатай холбоотой

Илрүүлэлт 1: Тайлант оны эцэст 2-5 жилийн насжилттай 183,388.9 мянган төгрөг, 5-с дээш жилийн насжилттай 120,753.3 мянган төгрөг, нийт 304,142.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах боломжгүй, найдваргүй авлага болох эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах нотлох баримтын бүрдлийг хангаж шүүхэд нэхэмжлэл гарган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж /30 цэг/-ийн 80,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж нийлүүлж байсан туршлагагүй, зар сурталчилгаа, нэвтрүүлэг хийх үйл ажиллагааны чиглэл бүхий "Парламентын суваг" ХХК-ийг шалгаруулан илт хууль бус гэрээ байгуулж, 65,917.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	1	65,917.5			1	65,917.5			1	65,917.5
Тус сан нь "Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх /182 сум/" арга хэмжээг нээлттэй тендер зарлаж 166,526.4 мянган төгрөгийн 182 ширхэг ПОС машин худалдан авч бараа материалд бүртгэн, Монгол шуудан ХК-ийн ашигт ажиллагааг сайжруулахаар тус ПОС машинуудыг ЦХИХХС-ын А/121 тоот дугаар тушаалаар балансаас	1	166,526.4			1	166,526.3				

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

балансад шилжүүлэн мөнгөн бус татаас олгосон байна.										
“Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5-д заасан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” судалгааны ажлын 19,500.0 мянган төгрөгийн гэрээг Хууль дээдлэх ёс НҮТББ-тай байгуулж, гүйцэтгэлээр алданги тооцож 18,564.0 мянган төгрөг олгосон байна. Тус судалгааны ажлын даалгаварыг зөв боловсруулаагүйгээс судалгааны тайлан нь хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал зөвлөмж дутмаг, нөхцөл байдал тайлбарласан байгаа нь хангалттай үр дүнгүй байна.	1	18,564.0			1	18,564.0				
Тайлант оны эцэст 2-5 жилийн насжилттай 183,388.9 мянган төгрөг, 5-с дээш жилийн насжилттай 120,753.3 мянган төгрөг, нийт 304,142.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах боломжгүй, найдваргүй авлага болох эрсдэлтэй байна.	1	304,142.2					1	304,142.2		
Нийт дүн	4	555,150.0			3	251,007.8	1	304,142.2	1	65,917.5

Санхүүгийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
"Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээ хүрээгүй алслагдсан орон нутгийн хүн амд үйлчилгээ хүргэх зорилгоор дамжуулах сүлжээний үйлчилгээ үзүүлэх /55 багт/" 2024-2025 онд хэрэгжих тендерийн техникийн тодорхойлолтыг судалгаанд үндэслэн бодитой боловсруулаагүйгээс 29 цэгийг өөрчлөн, гэрээний хугацааг 2026 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн хүртэл сунгаж захиалагчаас хамаарах шалтгаанаар "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-тай нэмэлт гэрээ байгуулсан байна.	1	-			1	-
Нийт дүн	1	-			1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1084/АД170039

Улаанбаатар хот

САГ-2026/4/ИА-СТА-ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж /30 цэг/-ийн 80,000,000.00 /Наян сая/ төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа техникийн тодорхойлолтод заасан нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж нийлүүлж байсан туршлагагүй, зар сурталчилгаа, нэвтрүүлэг хийх үйл ажиллагааны чиглэл бүхий “Парламентын суваг” ХХК-ийг шалгаруулан илт хууль бус гэрээ байгуулж, 65,917,500.00 /Жаран таван сая есөн зуун арван долоон мянга таван зуун/ төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.”, 41 дүгээр зүйлийн 41.1.6-д “захиалагчийн энэ хуульд заасан бусад зөрчил нь тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн нь төлбөрийн акт тогтоох үндэслэл бүрдээгүй бол” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж, илт хууль бус тендер шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Мягмарнаран/, ерөнхий нягтлан бодогч /С.Лхам/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-15.Docx

1526181377



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1085/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/4/НА-СТА-ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сан нь "Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх /182 сум/" арга хэмжээг нээлттэй тендер зарлаж 166,526,360.00 /Нэг зуун жаран зургаан сая таван зуун хорин зургаан мянга гурван зуун жаран/ төгрөгийн 182 ширхэг ПОС машин худалдан авч бараа материалд бүртгэн, Монгол шуудан ХК-ийн ашигт ажиллагааг сайжруулахаар тус Пос машинуудыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын А/121 тоот дугаар тушаалаар балансаас балансад шилжүүлэн мөнгөн бус татаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт төлөвлөөгүй, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар хориглосон мөнгөн бус татаас олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Мягмарнаран/, ерөнхий нягтлан бодогч /С.Лхам/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

9006109
УТА 16887
9025981411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-15.Docx

1526181380



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1086/А0170039

Улаанбаатар хот

САГ - 2026/4/МА - СТА - 3Г ТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


"Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө"-ний 5-д заасан "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох" судалгааны ажлын 19,500,000.00 /Арван есөн сая таван зуун мянган/ төгрөгийн гэрээг Хууль дээдлэх ёс НҮТББ-тай байгуулж, гүйцэтгэлээр алданги тооцож 18,564,000.00 /Арван найман сая таван зуун жаран дөрвөн мянган/ төгрөг олгосон байна. Тус судалгааны ажлын даалгаврыг зөв боловсруулаагүйгээс судалгааны тайлан нь хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал зөвлөмж дутмаг, нөхцөл байдал тайлбарласан байгаа нь хангалттай үр дүнгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Мягмарнаран/, ерөнхий нягтлан бодогч /С.Лхам/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Т.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-15.Docx

1526181379